

НОМЫН ЕРТӨНЦ

МАРКСИСТ ТҮҮХЭН ҮНЭН

С. Л. Тихвинский «Хятад ба дэлхий дахины түүх Москва, «Наука» 1988. 587 х.

Зөвлөлтийн хятадыг судлагч нэрт эрдэмтэн, академич С. Л. Тихвинскийн туурвисан энэхүү номонд хятад болон Азийн зарим улс орнуудын түүх, соёлын бүрэн судлагдаагүй асуудлуудыг манай энэ зууны дэлхий дахины түүхийн тулгамдсан асуудлуудтай холбон авч үзсэн ба 60—80-аад онуудад ЗХУ-аас улс түмний хоорондын энхтайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, харилцан ойлголцох, итгэлцлийг бэхжүүлэхийн төлөө өрнүүлсэн тэмцлийн түүхийг тодорхой харуулахыг зорилтоо болгожээ.

Эмхтгэлд орсон материалууд нь ЗХУ-д хэвлэгдсэн болон олон улсын түүхчдийн эрдэм шинжилгээний их хурлууд дээр түүний тавьсан судалгааны илтгэл, өгүүллүүдээс бүрдэл болж байна.

Хүн төрөлхтний түүхэнд шинэ эринийг нээсэн Октябрийн социалист их хувьсгалыг хүртэл ба Хятадын ажилчин ангийн тэмцэлд түүний улс төрийн манлай хүч болсон коммунист нам гарч ирэх үеийг хүртэл хятадын ард түмний тэмцэл, хөдөлгөөн дорвитой амжилт олж байсангүй. Октябрийн социалист хувьсгал Зөвлөлт-Хятадын ард түмний харилцаанд шинэ эринийг нээж, түүний хувьсгалжуулагч нөлөө Хятадад гүн гүнзгий нөлөөлсний нэгэн илрэл болсон Сунь-Ятсений «улс төрийн гурван зорилт» нь ЗХУ-тай болон ХКН-тай холбоо тогтоож, ажилчин тариачин олны хүчинд түшиглэхэд чиглэгдэж байв.

Сунь-Ятсен бол Зөвлөлүүдийн орны үнэнч нөхөр байсан бөгөөд түүний ертөнцийг үзэх үзэл төлөвшин тогтоход Октябрийн хувьсгалын болон Оросын ард түмний хувьсгалт тэмцлийн туршлага хэрхэн нөлөөлснийг авч үзэж ЗХУ-тай харилцах харилцаанд баримталж байсан тууштай, зарчимч байр суурийг нь тодорхой баримт, материал дээр тулгуурлан зохиогч үзүүлжээ.

Сунь-Ятсенийг амьд байх үед болон 1925 онд түүнийг нас барснаас хойш марксист ба хөрөнгөтний түүх зүйн төлөөлөгчдийн хооронд тэмцэл өрнөж, хөрөнгөтний зарим эрдэмтэд Сунь-Ятсений тодорхойлсон Хятадын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцлийн эхэн шатны нэгэн чухал зорилт байсан ЗХУ-тай тогтоосон харилцаа, холбоог элдвээр гутаахыг оролдсон юм. Хөрөнгөтний түүх зүйчид Сунь-Ятсений үзлийг судалж үзэхдээ зөвхөн түүхэн бие хүнтэй нь холбож явцууруулах тал байна. Гэвч Хятадын нэрт хувьсгалч, ардчилсан үзэлтэний нь хувьд Сунь Ятсений амьдрал, үйл ажиллагааг сонирхон судлах явдал орчин үед өсөн нэмэгдсээр байна.

Зөвлөлтийн хятад судлалд 30—60-аад онуудад дээрх чиглэлээр судалгаа шинжилгээний бүтээлүүд ихээхэн хэмжээгээр нийтлэгджээ. Зохиогч, уг номондоо сүүлийн жилүүдэд хөрөнгөтний судлаачдын туурвисан Сунь-Ятсений холбогдолтой бүтээлүүдэд дүн шинжилгээ хийжээ. Тухайлбал, Америкийн К. М. Уилбур, Баруун Германы Г. К. Киндерман, Изралийн Г. Шифрин, Францын М. К. Бержер нарын зэрэг эрдэмтдийн бүтээл дэх Сунь-Ятсений ЗХУ-тай холбогдсон асуудлууд болон улс төрийн гурван зорилтын нь нэг байсан коммунист нам, гоминь,

дантай холбоо тогтоох зэрэг 70-аас 80-аад оны эхэн хагас хүртэл барууны түүхчдийн дунд идэвхжсэн Сунь-Ятсен судлалын асуудалд анхаарлаа чиглүүлжээ. Өөр нэгэн чухал судалгаа нь Сунь-Ятсений гадаад эдийн засгийн үзэл бодолд чиглэсэн ба тухайлбал, Хятадын хяналтын дор гадаадын капитал оруулах «Нээлттэй хаалгын» бодлогын оролцоотойгоор хятадын аж үйлдвэрийг хөгжүүлэх Сунь-Ятсений төлөвлөгөөтэй холбогдсон сэдвүүдийг барууны түүхчид хэрхэн үзэж буйд дүн шинжилгээ хийжээ.

Мөн зохиогчийн сонирхсон судалгааны хүрээнд дундад зууны болон шинэ, шинэхэн үеийн Хятадын түүхийн асуудлууд хамрагдсан бөгөөд гол анхаарлаа Хятадын түүх ба дэлхий дахины түүхэн үйл явцын нэгдлийн жишээн дээр үзүүлэхийг зорьжээ.

Синьхайн хувьсгал бол хятадын ард түмний ардчилсан ба үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүхэнд чухал үе шат болсон бөгөөд түүний үзэл санаа нь хөрөнгөтний үндсэрхэг үзэлтэй эрс харшилж байв. Ер нь XIX зууны Хятад оронд шинэчлэлийн төлөө хөдөлгөөн их эрчимжсэн юм. Хотуудад капиталист харилцаа өргөжин, тосгонд таваар мөнгөний харилцаа хөгжсөнөөр орчин үеийн аж үйлдвэрийн суурь тавигдан дэлхийн нийт зах зээл рүү Хятад улс түрэгдэн орсон юм.

Зохиогч энэхүү судалгаандаа XIX зууны сүүл үеийн хятад эх сурвалжуудыг юуны өмнө Кан-Ювэй болон бусад реформист удирдагчдын зохиол бүтээлүүд болон тэмцэл хөдөлгөөнд оролцогчдын хэлсэн үг, эзэн хаадын зарлиг, тушаалууд, албан ёсны дурсамж дурдатгалууд, тухайн эринд хэвлэгдэж байсан хэвлэл зэрэг ховор материалуудыг ашигласнаас гадна, Кан Ювэй ба бусад удирдагчдын онолын асуудлыг судлахад кунзийн сонгодог зохиолуудыг түшиглэжээ. Кан Ювэй (1858—1927) бол «Аугаа их нэгдэл» хэмээгч, утопи онолыг үндэслэгч юм. Тэрээр 1895—1898 онуудад өрнөсөн шинэчлэлийн төлөө хөдөлгөөний удирдагч бөгөөд Хятад орны капиталист хөгжлийн замыг бодитойгоор нээн харуулахад түүний үзэл нь ихээхэн үүрэгтэй байв.

1894—1895 оны Япон-Хятадын дайныг хүртэл хятадын нийгмийн зарим төлөөлөгчид Хятадад шинэчлэл хийх нь зайлшгүй шаардлагатай болохыг ухамсарлаж ирсэн байна. Тэдний тоонд Фэн-Гуйфэн, Чжэн-гуаньин, Сюэ-Фучэн, Ма-Цзяньчжун, Тань-Сытун нарыг дурьдаж болохоос гадна тэдний томоохон төлөөлөгч Тань-Сытун бол XIX зууны сүүл хагасын Хятадын шинэчлэлийн төлөө хөдөлгөөний нэгэн нэрт үзэл сурталч юм. Түүний улс төрийн үзэл санаа ба нийгэм-улс төрийн үйл ажиллагаа нь Чин улсын ноёрхлын эсрэг хятадын ард түмний тэмцэлд гүнзгий нөлөөлснөөс гадна XX зууны Хятадын ардчилсан үзэлтнүүдэд ч зохих нөлөөг үзүүлжээ. Иймээс ч зохиогч номон доо XIX зууны шинэчлэлийн төлөө хөдөлгөөний төлөөлөгчдийн үзэлд дүн шинжилгээ хийснээс гадна Хятадын дундад зууны түүхийг судалсан Зөвлөлтийн эрдэмтэд тухайлбал З. Г. Лапин, С. Н. Гончаров, Е. В. Завадский, А. А. Бокщанин нарын бүтээлд дүн шинжилгээ хийжээ. Мөн орос-зөвлөлтийн хятад судлагчид Хятадын олон зууны соёлыг хэрхэн судалж сурталчилсан тухай өгүүлж байна. «Соёлын хувьсгал»-ын жилүүдэд Хятад улс өөрийн музей, номын сан, их, дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудынхаа үйл ажиллагааг хааж соёлын олон зүтгэлтнүүд нь харгислалд өртөж байхад ЗХУ-д Хятадын зохиол бүтээлийг хэвлэж, орчуулах ажил өрнөж хятадын соёлыг сурталчлах явдал тасралтгүй үргэлжилж байв.

Иймээс ч зохиолч дэлхийн олон түмэнд Хятадын соёлыг хүргэн сурталчлахад чухал хувь нэмэр оруулсан Орос-зөвлөлтийн болон зөвлөлтийн нэрт хятад судлагч Н. Бичурин, А. П. Рогачев, И. М. Ошанин, В. М. Алексеев нарын гавьяаг онцлон тэмдэглэжээ. Түүнчлэн уг номын өөр нэг хэсэг нь Хятадын түүхийн асуудлаар БНХАУ-д болсон эрдэм шинжилгээний их хурлуудын тухай юм. Үүнд 1986 онд Шанхайд хуралдсан Хятадын соёлын асуудал хэлэлцсэн их хурал, мөн оны 11-р сард Гуаньчжоу ба Цуйхэнцунь тосгонд болсон «Сунь-Ятсен ба түүний эрин үе» зэрэг хурлууд хамрагдаж байна. Эдгээр хурлууд нь Хятадын болон гадаадын судлаачдын сонирхлыг ихэд татсан ба зохиогч өөрийн биеэр хоёр хуралд нь оролцжээ.

Зохиогч, номдоо зөвлөлт төрийн гадаад бодлогын түүхэнд холбогдох судалгааг баялаг баримтад тулгуурлаж энхтайвны тухай зөвлөлт төрийн ленинч хуулиас өнөөг хүртэлх үеийн залгамж, бодлогыг хамруулжээ. Тэрээр 1960—1985 онуудад ЮНЕСКО-гийн шугамаар олон улсын түүхчдийн 6 удаагийн их хуралд оролцож уг их хурлуудын шинжлэх ухааны үр дүнтэй уншигч олныг танилцуулж буй нь дэлхий нийтийн түүхийн шинжлэх ухааны ололт, хөгжлийн хандлага, байдлыг цэгнэн үзэх боломж олгож байна.

Ази, Номхон далайн аюулгүй байдлын асуудал бол ЗХУКН ба Зөвлөлт төрийн олон улсын үйл ажиллагааны нэгэн чухал салбар юм. 70—80-аад оны заагт ЗХУ энэ бүс нутгийн бүх улсуудын хамтын хүчин чармайлтын үндсэн дээр Азийн аюулгүй байдлыг хангах бодлогыг дэвшүүлсэн юм. Зохиогчийн судалгааны хүрээнд энэ асуудал тодорхой байрыг эзэлсэн ба Ази, Номхон далайн бүс нутагт, АНУ-ын явуулж буй бодлогыг харуулсан Р. Венкама нарын зэрэг америкийн зарим эрдэмтдийн бичсэн бүтээлүүдэд шүүмжлэлтэйгээр ханджээ.

Энэхүү номын төгсгөлийн хэсэгт цөмийн эрин үед амьдарч байгаа түүхчдийн өмнө тулгарч байгаа үүрэг, хариуцлага, оруулж буй хувь нэмрийн тухай асуудлыг авч үзжээ. Манай эх дэлхий бол харилцан нягт холбоо, шүтэлцээтэй учраас улс төр, эдийн засаг, соёл, зэвсэгт хүчин зэрэг шинжлэх ухааны олон салбарын эрдэмтдийн нэгдмэл хамтын ажиллагааг шаардаж байна. Иймээс хамтран ажиллах, харилцан ойлголцоход түүхэн уламжлал ба түүхэн энэрэнгүй үзэл чухал болох бөгөөд улмаар цөмийн дайны аюулаас хүн төрөлхтнийг ангижруулах энхийн эрхэм үйлсэд түүхчид их хувь нэмэр оруулж ирсэн, оруулж ч байгаа тухай өгүүлжээ.

Зөвлөлтийн нэрт хятад судлалч, академич С. Л. Тихвинскийн туурвисан «Хятад ба дэлхий дахины түүх» хэмээх энэхүү ном нь марксист шинжлэх ухааны арга зүйн үндсэн дээр дэлхий дахины түүх тухайлбал, хятад болон Азийн зарим орны түүх, соёлын асуудлуудтай уншигч өргөн олныг танилцуулж байгаагаараа чухал ач холбогдолтой бүтээл болжээ.

Д. Баясгалан